



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathatural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020 10 01 № 23

Г Асуулт тавих тухай Г

Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, дарамт гэр бүлийн болон бусад нөхцөлд үйлдэгдэж байгаа явдлыг таслан зогсоох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэхэд салбар хоорондын уялдааг сайжруулах, мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн сурталчилгааг идэвхжүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай гэж үзсэн тул Улсын Их Хурлын зарим гишүүд Улсын Их Хурал дахь "Хүчирхийлэлтэй тэмцэх лобби бүлэг" байгуулан ажиллаж байна.

Хүчирхийлэлтэй холбоотой дээр дурдагдсан асуудлуудад дүн шинжилгээ хийн шаардлагатай арга хэмжээнүүдийг авахын тулд тэдгээрийн нөхцөл байдал, тоо баримт, дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай байх тул миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.7-д тус тус заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуултыг тавьж байна. Асуултын хариуг 2017-2020 оны байдлаар гарган ирүүлнэ үү.

1. Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэл;
2. Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээлэл;
3. Хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаарх бүртгэл хөтлөлт, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтийн байдлын тухай;
4. Түр хамгаалах байрны нөхцөл байдал, үйлчилгээ үзүүлсэн байдлын талаарх тоо баримт;
5. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээлэл, тоо баримт;
6. Сэтгэл засал, хууль, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн байдлын тоон мэдээлэл;
7. Хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлж буй байдлын талаарх мэдээлэл, судалгаа зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.БАЯРСАЙХАН



2020000036